



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Дүүргийн “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 16.3, 16.4, 16.5 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 37 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхэд хамгааллын тухай хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан дүүргийн “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, дүрмийг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.


2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 2024 оны А/67 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 2 сарын 22-ны өдрийн 188 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ДҮҮРГИЙН “ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛ”-ИЙН ШИНЭЧИЛСЭН БҮРЭЛДЭХҮҮН

Хүүхдийн төлөө зөвлөлийн

дэд дарга:

Засаг даргын орлогч

Гишүүд:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

бөгөөд Ажлын албаны дарга (зөвшилцсөнөөр)

Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн
хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа,
үйлчилгээний хэлтсийн дарга

1 дүгээр хорооны Засаг дарга

2 дугаар хорооны Засаг дарга

Эрүүл мэндийн төвийн дарга

Боловсролын хэлтсийн дарга

Цагдаагийн хэлтсийн дарга

Онцгой байдлын хэлтсийн дарга

Соёлын ордны захирал

Биеийн тамир, спортын хорооны дарга

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга

“Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын захирал

“Багахангай гэрэлтүүлэг ногоон байгууламж”
ОНӨААТҮГ-ын захирал

Багахангайн теле хяналтын камерын дэд төвийн
захирал

Дүүргийн “Хүүхдийн зөвлөл”-ийн тэргүүн


Дүүргийн “Хүүхдийн элч”

Төрийн бус байгууллагын төлөөлөл (зөвшилцсөнөөр)

Эцэг, эхийн төлөөлөл (зөвшилцсөнөөр)

Нарийн бичиг:

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Дүүргийн Хүүхдийн төлөө (цаашид зөвлөл гэх) нь хүүхдийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагуудад зөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, идэвх оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, талуудын оролцоо, санал санаачилгуудыг дэмжих чиг үүрэг бүхий орон нутгийн зөвшлийн байгууллага юм.
- 1.2 Зөвлөлийн зорилго нь хүүхдийн талаар төрөөс явуулж байгаа бодлого, хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомж, Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын үзэл санааг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт болон холбогдох бусад байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх, хүүхэд хөгжүүлэх, хамгаалах дүүргийн хөтөлбөрийн үйл ажиллагааг зохицуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавихад чиглэнэ.
- 1.3 Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах хууль, холбогдох хууль тогтоомж, хүүхдийн эрхийн конвенц болон энэхүү дүрмийн удирдлага болгоно.

Хоёр. Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

- 2.1. Зөвлөлийг Дүүргийн Засаг дарга тэргүүлнэ.
- 2.2. Зөвлөл нь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, эцэг эх, хүүхдийн төлөөллөөс бүрдэнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Дүүргийн Засаг дарга томилно.
- 2.3. Зөвлөл ажлаа жилээр төлөвлөж хэрэгжүүлэх ба зөвлөлийн хуралдааныг зөвлөлийн дарга удирдан улирал тутамд 1 удаа улирлын эхний сарын 05-ны дотор хуралдуулна.
- 2.4. Салбар зөвлөл жилийн ажлын төлөвлөгөө батлуулахаас өмнө Нийслэлийн Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын албанд танилцуулна.
- 2.5. Зөвлөл тухайн хурлаар хэлэлцсэн асуудал, тайлан мэдээг улирлын эхний сарын 10-ны дотор Нийслэлийн хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын албанд ирүүлнэ.
- 2.6. Цаг үеийн холбоотой асуудлаар ээлжит бус хуралдааныг зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно.
- 2.7. Гишүүдийн олонх бүрдсэнээр зөвлөл хуралдана. Зөвлөлийн тэргүүний зөвшөөрснөөр гишүүн саналаа бичгээр ирүүлж болно. Хэлэлцсэн асуудлыг гишүүдийг олонхын саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд асуудлыг зөвлөлийн даргын саналаар шийдвэрлэнэ.
- 2.8. Зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг зөвлөлийн нарийн бичиг хариуцна.
- 2.9. Зөвлөлийн хуралдаанаар хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тулгамдсан асуудал, ажлын төлөвлөгөө, тайлан болон бусад асуудлыг хэлэлцэн тогтоол гаргаж, биелэлтийг нь хангуулна.

- 2.10. Зөвлөлийн шийдвэр нь “Зөвлөлийн тогтоол” байх ба зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 2.11. Зөвлөлийн шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хороодын Засаг даргаар дамжуулан хэрэгжүүлнэ.
- 2.12. Зөвлөлийн дэргэд тодорхой чиглэлээр эрдэмтэн, мэргэжилтэн, зөвлөхүүдийн ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.
- 2.13. Зөвлөлийн ажлын албаны үүргийг хүүхдийн эрхийг хамгаалах төрийн чиг үүрэг бүхий орон нутгийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. Ажлын албаны дарга нь зөвлөлийн нарийн бичгийн дарга байна.
- 2.14. Зөвлөлийн гишүүн нь Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд иргэн, төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах бүрэн эрх эдэлнэ.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл

- 3.1.1 Хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжүүлэх, оролцуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар дүүргийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага холбогдох бусад байгууллагад зөвлөх ба санал дэвшүүлэх
- 3.1.2 Хүүхдийн талаарх дүүргийн бодлогыг хэрэгжүүлэхэд төр, олон нийт, иргэд аж ахуйн нэгж байгууллага, эцэг эх, хүүхдийн оролцоог ханга ажиллана
- 3.1.3 Хүүхдийн эрх, хамгаалал, хөгжил, оролцоотой холбоотой төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Дүүргийн өөрөө удирдах байгууллага, төрийн захиргааны болон холбогдох байгууллагууд, албан тушаалтны тайлан мэдээллийг сонсох энэ талаар цаашид авах арга хэмжээнд оруулах саналаа Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал Засаг дарга болон холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх
- 3.1.4 Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл, судалгааны санг бий болгож, үйлчилгээний үр дүнг нийтэд хүртээмжтэй, ил тод болгох, хүүхдийн эрхэд суурилсан бодлогын хэрэгжилт, үр дүнг хянах олон нийтийн хяналтын тогтолцоог төлөвшүүлэх
- 3.1.5 Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах хууль тогтоомж боловсруулах, хүүхдийн эрхийн баталгааг бүрдүүлэхэд чиглэсэн санал боловсруулна.
- 3.1.6 Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах, асуудлаар олон улсын болон гадаад дотоодын төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнтэй хамтран ажиллана.
- 3.1.7 Хүүхдийн эрхийг зөрчсөн үйл ажиллагааг зогсоох, гаргасан шийдвэрийг өөрчлөх, цуцлах саналыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Зөвлөлийн эрх, үүрэг

- 4.1 Зөвлөл дараах эрхийг эдэлнэ
- 4.1.1 Хүүхдийн талаарх Дүүргийн бодлогыг хэрэгжүүлэхэд хүүхэд, иргэд олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулах тэдгээрийн дэвшүүлсэн санал санаачилгыг дэмжих
- 4.1.2 Хүүхдийн төлөө санг зохих хууль тогтоомжийн дагуу байгуулж, сангийн үйл ажиллагааг тогтмолжуулахад санаачилгатай ажиллах

- 4.1.3 Хүүхдийн эрхийг хамгаалах үйлсэд идэвх зүтгэл гаргаж, үр бүтээлтэй ажилласан хүүхэд иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг шагнах, урамшуулах саналыг Нийслэлийн хүүхдийн төлөө зөвлөлд хүргүүлэх
- 4.2 Зөвлөл дараах үүргийг хэрэгжүүлнэ
 - 4.2.1 Хүүхдийн эрхийг зөрчсөн үйл ажиллагааг зогсоох, гарсан шийдвэрийг өөрчлөх, цуцлах саналыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх
 - 4.2.2 Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, материалыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдээс гаргуулан авах
 - 4.2.3 Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг түүний ажлын алба жилийн төсөвтөө тусгаж батлуулна.

Тав. Хариуцлага

- 5.1. Хүүхдийн төлөө зөвлөл, зөвлөлийн гишүүд нь хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн нь тогтоогдвол зөвлөлийн хуралдаанаар асуудлыг хэлэлцэнэ.